



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 01 өдөр

Дугаар A/568.

Булган сум

Г Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээр бүртгэх тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэхь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 641 дүгээр тогтоолоор баталсан "Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Баянмөнх овогтой Уламбаяр"-г барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэнээр бүртгэсүгэй.

2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж зохих үйл ажиллагааг хуулийн дагуу эрхэлж, холбогдох тайлан, мэдээг хууль, журмын дагуу тайлагнаж байхыг (Б.Уламбаяр)-г үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

